



БОГД БАНК
ИТГЭЛ ТҮГЭЭНЭ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2025.02.18

№ 15/17

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46, 47, 76 дугаар зүйлийн 76.1.12 дэх заалт, 80 дугаар зүйлийн 80.6, Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3, Богд банкны дүрмийн 8 дугаар зүйл 8.14.10, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлын шийдвэрлэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Богд банк” ХК-ийн 2024 оны 2-р хагас жилийн урьдчилсан байдлаарх татварын дараах цэвэр ашиг 25,156,527,760.73 төгрөгийн 20 хувь болох 5,031,305,552.15 төгрөгийг нийт эргэлтэд байгаа хувьцаанд тооцон нэгж хувьцаанд 4.00 төгрөгийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Нэг төрлийн хувьцаанд ногдох ногдол ашгийн дүнг адил хэмжээнд байхаар тогтоосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж болон Үнэт цаасны компаниудаар дамжуулан Монголбанкнаас зөвшөөрөл ирснээс хойш 5 хоногийн дотор хуваарилсугай.
5. Энэхүү тогтоолыг банкны болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигч нарт мэдэгдсүгэй.
6. Хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарсан өдрөөс хойш ногдол ашиг хуваарилах хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бөгөөд тэдгээрийн хооронд байгуулагдсан гэрээнд өөрөөр заагаагүй бол хувьцааны хуучин эзэмшигчид ногдол ашиг хуваарилагдах болохыг дурдсугай.
7. Тогтоолын хувийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх (Г.Саруул)-д даалгасугай.
8. Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх (Г.Саруул)-д даалгасугай.
9. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулан ажиллахыг Дотоод аудитын газар (Д.Төрмандах)-д үүрэг болгосугай.
10. Ногдол ашиг хуваарилалтын тайланг банкны хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, тайлагнахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Л.Болдхуяг)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ